



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/43/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах Аудитор Д.Цэрэнханд Утас: 99147999 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn</p>	
---	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ ЧАНДМАНЬ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.17 № 02

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07030012

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,847,008.44</b>	<b>54,609,505.08</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>433,387.62</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>433,387.62</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>433,387.62</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	386,616.57
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	46,771.05
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>1,080,000.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	1,080,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>27,847,008.44</b>	<b>53,096,117.46</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>8,778,530.44</b>	<b>16,507,257.46</b>
35130	Эм боох материал	8,778,530.44	16,507,257.46
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>19,068,478.00</b>	<b>36,588,860.00</b>
35410	Бичиг хэргийн материал	409,250.00	409,250.00
35420	Аж ахуйн материал	17,245,040.00	35,581,540.00
35430	Сэлбэг хэрэгсэл	35,000.00	35,000.00
35440	Түлш, шатах тослох материал	963,480.00	400,000.00
35460	Хүнсний материал	415,708.00	163,070.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>555,103,001.69</b>	<b>408,147,053.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>555,103,001.69</b>	<b>408,147,053.93</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>549,569,001.69</b>	<b>402,613,053.93</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	518,458,790.09	409,853,575.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,609,363.95	-47,949,013.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,783,192.60	36,676,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,019,981.87	-27,177,295.47
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	200,837,573.00	219,617,922.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-140,980,724.86	-193,821,852.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,596,532.40	14,596,532.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,535,641.31	-11,953,140.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,877,713.35	15,877,713.35
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,988,052.76	-13,256,786.64
39217	Ном	148,965.00	148,965.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,534,000.00</b>	<b>5,534,000.00</b>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,534,000.00	5,534,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>582,950,010.13</b>	<b>462,756,559.01</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>6,556,564.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>6,556,564.70</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>6,556,564.70</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>6,556,564.70</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	6,556,564.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>582,950,010.13</b>	<b>456,199,994.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>582,950,010.13</b>	<b>456,199,994.31</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	307,424,380.50	307,424,380.50
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-48,576,905.19</b>	<b>146,481,818.80</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	14,313,278.67	273,231,834.62
51220	Тайлант үеийн үр дүн	-62,890,183.86	-126,750,015.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	324,102,534.82	2,293,795.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>582,950,010.13</b>	<b>462,756,559.01</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>408,960,322.70</b>	<b>721,682,912.73</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,724,272.70</b>	<b>183,064,718.73</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>31,724,272.70</b>	<b>183,064,718.73</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>24,172,681.70</b>	<b>183,064,718.73</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,500,000.0	167,743,269.08
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,672,681.70	15,321,449.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>377,236,050.00</b>	<b>538,618,194.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>344,589,100.00</b>	<b>387,007,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,589,100.00	387,007,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,521,100.00</b>	<b>126,973,284.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,397,600.00	3,267,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	423,500.00	1,740,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	121,965,984.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>10,940,600.00</b>	<b>16,055,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,940,600.00	16,055,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,185,250.00</b>	<b>8,582,410.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,185,250.00	8,582,410.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>471,850,506.56</b>	<b>764,890,455.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>471,850,506.56</b>	<b>764,890,455.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>471,218,753.07</b>	<b>735,672,624.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>261,466,725.48</b>	<b>338,581,547.02</b>
210101	Үндсэн цалин	261,329,974.48	338,581,547.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,141,355.00</b>	<b>45,419,919.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,645,355.00	32,976,410.99
210202	Тэтгэмжийн даатгал	2,624,000.00	3,096,102.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,099,200.00	2,503,477.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,800.00	622,175.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,248,000.00	6,221,755.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,013,653.53</b>	<b>10,820,289.20</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,276,153.53	2,755,789.20
210302	Түлш, халаалт	6,137,500.00	7,464,500.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,109,725.50</b>	<b>29,450,949.77</b>
210401	Бичиг хэрэг	1,335,950.00	1,434,560.00
210402	Тээвэр, шатахуун	22,631,717.50	25,532,907.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	782,100.00	742,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	120,000.00

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,956,785.00	671,600.00
210408	Бараа материал акталсны зардал	1,403,173.00	949,282.77
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,200,268.28</b>	<b>218,653,969.36</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,367,217.28	210,768,958.36
210502	Хоол, хүнс	4,367,222.00	7,885,011.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,041,600.00</b>	<b>5,219,480.00</b>
210604	Урсгал засвар	2,038,000.00	5,219,480.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,130,000.00</b>	<b>2,008,555.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,130,000.00	2,008,555.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,969,450.00</b>	<b>1,022,390.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544,000.00	290,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	33,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	643,700.00	699,390.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,145,975.28</b>	<b>84,495,524.43</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,096,250.00	2,301,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,049,725.28	82,193,824.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>631,753.49</b>	<b>29,217,830.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>29,020,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	29,020,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>129,938.97</b>	<b>197,830.80</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,446.47	197,830.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-62,890,183.86</b>	<b>-43,207,542.84</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>83,542,472.98</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	83,542,472.98
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-62,890,183.86</b>	<b>-126,750,015.82</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,424,380.50	324,102,534.82	14,313,278.67	645,840,193.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	307,424,380.50	324,102,534.82	14,313,278.67	645,840,193.99
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-62,890,183.86	-62,890,183.86

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,424,380.50	324,102,534.82	-48,576,905.19	582,950,010.13
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	307,424,380.50	324,102,534.82	-48,576,905.19	582,950,010.13
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	321,808,739.81	321,808,739.81
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>307,424,380.50</b>	<b>324,102,534.82</b>	<b>273,231,834.62</b>	<b>904,758,749.94</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	321,808,739.81	0.00	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-126,750,015.82	-
20	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>307,424,380.50</b>	<b>2,293,795.01</b>	<b>146,481,818.80</b>	<b>456,199,994.31</b>

Говь-Алтай аймаг дахь  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>377,236,050.00</b>	<b>537,538,194.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>377,236,050.00</b>	<b>537,538,194.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>344,589,100.00</b>	<b>387,007,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,589,100.00	387,007,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,521,100.00</b>	<b>125,893,284.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,397,600.00	3,267,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	423,500.00	1,740,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	120,885,984.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>10,940,600.00</b>	<b>16,055,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,940,600.00	16,055,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,185,250.00</b>	<b>8,582,410.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,185,250.00	8,582,410.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>374,386,050.00</b>	<b>533,645,906.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>374,386,050.00</b>	<b>533,645,906.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>373,754,296.51</b>	<b>504,428,075.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>261,466,725.48</b>	<b>338,581,547.02</b>
210101	Үндсэн цалин	174,266,725.48	211,783,761.02
210102	Нэмэгдэл	64,000,000.00	62,400,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,200,000.00	6,000,000.00
210104	Урамшуулал	18,000,000.00	41,697,786.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	16,700,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,141,355.00</b>	<b>45,419,920.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,645,355.00	32,976,411.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,624,000.00	3,096,102.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,099,200.00	2,503,477.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,800.00	622,175.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,248,000.00	6,221,755.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,933,653.53</b>	<b>10,860,289.20</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,276,153.53	2,755,789.20
210302	Түлш, халаалт	7,057,500.00	7,504,500.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,163,007.50</b>	<b>27,889,777.00</b>
210401	Бичиг хэрэг	1,248,200.00	1,422,450.00
210402	Тээвэр, шатахуун	21,499,107.50	24,929,427.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	782,100.00	742,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,000.00	120,000.00

**Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	553,600.00	675,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,199,205.00</b>	<b>70,438,307.36</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,989,025.00	64,326,277.36
210502	Хоол, хүнс	3,390,180.00	6,112,030.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,712,100.00</b>	<b>5,893,480.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	819,600.00	896,600.00
210604	Урсгал засвар	892,500.00	4,996,880.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,749,500.00</b>	<b>2,008,555.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,749,500.00	2,008,555.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,047,500.00</b>	<b>1,023,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544,000.00	290,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	33,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	721,750.00	700,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,341,250.00</b>	<b>2,313,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,341,250.00	2,313,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>631,753.49</b>	<b>29,217,830.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>29,020,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	29,020,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>129,938.97</b>	<b>197,830.80</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,446.47	197,830.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,850,000.00</b>	<b>3,892,287.62</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,850,000.00</b>	<b>3,458,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,850,000.00</b>	<b>3,458,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,850,000.00</b>	<b>3,458,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,850,000.00	3,458,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,850,000.00</b>	<b>-3,458,900.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>433,387.62</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	433,387.62

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>426,871,800.00</b>	<b>411,060,462.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>426,871,800.00</b>	<b>411,060,462.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>426,271,800.00</b>	<b>410,460,462.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>303,700,000.00</b>	<b>303,411,215.02</b>
210101	Үндсэн цалин	189,000,000.00	188,711,215.02
210102	Нэмэгдэл	62,400,000.00	62,400,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,000,000.00	6,000,000.00
210104	Урамшуулал	29,600,000.00	29,600,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,700,000.00	16,700,000.00


Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>40,999,500.00</b>	<b>40,999,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,851,500.00	28,851,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,037,000.00	3,037,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,429,600.00	2,429,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	607,400.00	607,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,074,000.00	6,074,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,600,000.00</b>	<b>10,860,289.20</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,755,789.20
210302	Түлш, халаалт	9,000,000.00	7,504,500.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,959,300.00</b>	<b>25,590,350.00</b>
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,160,950.00
210402	Тээвэр, шатахуун	22,966,500.00	22,966,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	667,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	675,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,960,700.00</b>	<b>16,920,528.41</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,960,700.00	11,408,298.41
210502	Хоол, хүнс	6,000,000.00	5,512,230.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,618,900.00</b>	<b>8,352,380.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,618,900.00	3,355,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,996,880.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>990,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	990,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,107,200.00</b>	<b>1,023,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	290,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,200.00	33,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	700,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,326,200.00</b>	<b>2,313,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,326,200.00	2,313,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>426,871,800.00</b>	<b>411,644,910.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>387,007,500.00</b>	<b>387,007,500.00</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	387,007,500.00	387,007,500.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>17,600,000.00</b>	<b>16,055,000.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	17,600,000.00	16,055,000.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>22,264,300.00</b>	<b>8,582,410.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,264,300.00	8,582,410.00

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	386,616.57
---	---	------	------------

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	125,846,512.95
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	125,846,512.95
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	97,426,512.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	35,170,332.00
210101	Үндсэн цалин	23,072,546.00
210104	Урамшуулал	12,097,786.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,420,420.00
210201	Тэтгэврийн даатгал	4,124,911.00
210202	Тэтгэмжийн даатгал	59,102.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	73,877.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,775.00
210205	Эрүүл мэндийн даатгал	147,755.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,299,427.00
210401	Бичиг хэрэг	261,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,927.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	54,517,778.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,917,978.95
210502	Хоол, хүнс	599,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,018,555.00
210702	Дотоод албан томилолт	1,018,555.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,420,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,771,051.05



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын нөөцийг оновчтой төлөвлөж эрүүл мэндийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг сайжруулан хяналтын тогтолцоог бэхжүүлж бодлогыг тодорхойлох. Эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж эрсдэлийг бууруулах гүйцэтгэлд суурилсан хариуцлага хяналтын тогтолцоо иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, Хүн амыг Хүүхэд насанд амьдралд идэр насанд амьдралын чанарыг хангахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 471.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 764.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 12.2 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25 хувиар буюу 120.2 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө данс эхний үлдэгдэлгүй, 0.43 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53.0 сая төгрөг болж 25.2 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 114.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 166.7 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 255.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.9 сая төгрөгийн эмийг акталж устгасан байна. Оны эцэст 53.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 702.8 сая төгрөг болж 103.7 сая төгрөгөөр буурсан нь 108.6 сая төгрөгийн барилгыг шилжүүлсэнтэй холбоотой. Төсвийн хөрөнгөөр 3.46 сая төгрөгийн, хандиваар 15.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж авч, 13.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган, 108.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.


Авлага дансанд эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 1,08 сая төгрөг нь ЭМДСангаас авах авлага ба тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Өглөг дансанд эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 6.5 сая төгрөг нь эмийн өглөг ба тооцоо нийлж тулган баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 456.2 сая төгрөг болж 126.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 76 хувиар буюу 311.7 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотойгоор үнэ төлбөргүй бараа материал, хөрөнгө ирсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 146.4 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 466.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 39.8 сая төгрөгөөр бууруулж, 426.8 сая төгрөгөөр баталжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 426.8 сая төгрөгийн төсөв баталснаас 387.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 17.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22.2 сая төгрөгийг ЭМДСангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 387.0 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 16.0 сая төгрөг, ЭМДСангаас 8.5 сая төгрөгийг авч, урсгал үйл ажиллагаанд 411.0 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 0.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 0.38 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. ЭМДСангаас 13.8 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 1.7 сая төгрөгийн санхүүжилтийг нийт 15.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 411.2 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 0.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.7 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1.3, нормативд зардлыг 10.0 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 1.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн дээд шатны төсөв захирагчаас 120.8 сая төгрөг, хандивын орлого 3.3 сая төгрөг, шинжилгээний орлогоос 1.3 сая төгрөг нийт 125.88 сая төгрөгийн орлого орж, 125.84 сая төгрөгийг зарцуулж, 0.046 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийг цар тахалтай холбоотойгоор ажиллагсад вакцины урамшуулал, тэтгэмж, илүү цаг, эмийн зардалд тус тус зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.


### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**



Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 313.9 сая төгрөгийн 50 мэдээллийг ил тод байршуулахаас 177.6 сая төгрөгийн 20 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 2.0 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн, 6.9 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү шивүүлснийг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т заасан заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.5 сая төгрөгийг залруулж, 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 28.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан байна. Өмнөх шийдвэрийн үлдэгдэлгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараа жилийн аудитаар эм боох материалын нэр төрлийн зарцуулалт, бараа материалын тайлангийн тулгалт, төсвийн хэмнэлтийн горимыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 18.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Тайлант онд 7.5 сая төгрөгийн худалдан авалтын И баримтыг илүү дутуу шивүүлснийг аудитын явцад залрууллаа

### **4.2 Төлбөрийн акт**

Илүү цагийг тооцож олгоходоо бодогдсон цалингаас тооцож 0.7 сая төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### **4.3 Албан шаардлага**

Татварын тайлангаар 8.0 сая төгрөгийн дутуу, 0.03 сая төгрөгийн илүү төлөлттэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг

шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцэхгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 1.1 сая төгрөгийн зарлага гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 2.0 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.


#### 4.4 Зөвлөмж

Шилэн дансанд 177.6 сая төгрөгийн орлогын 20 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргүүлээ

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Чандмань сумын ЭМТ	6	18.8	1	6.9	1	0.7	3	11.1	1	
	Дүн	6	18.8	1	<b>6.9</b>	1	0.7	3	11.1	1	



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Код:	
Баримт бичгийн төрөл	Санхүүгийн тайлангийн аудлит
Аудитын нэр	Чандмань сумын ЭМТ
Хугацаа заасан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй
Ажил гүйцэтгэсэн:	Ахлах аудитор Аудитын менежер

Д.Цэрэнханд  
Д.Эрдэнэчимэг

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эрээцийн хүснэгт

Огноо	Хүлээн авсан	Буцааж өгсөн	Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
			Хангалттай	Зөвөөр, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Зөвөөр хийгээд дахин үзүүлэх				
2022.02.11	2022.02.11		+			Халбэлзлээ оруулж, хянах		Ж.Бүжинханд	Халбэлзлээ шивж оруулан хяналаа
2022.02.11	2022.02.11		+			1 сая төгрөгийн авлага, 577.0 сая төгрөгийн өглөгтэй байхад өглөг авлагын дэлгэрэнгүйг бөглөөгүй байна		Ж.Бүжинханд	Өглөг, авлагын судалгааг оруулсан
2022.02.11	2022.02.11		+			Акталсан эм, эмнэлгийн хэрэгслийн дүнд шийдвэр өгөх /Учир нь тендэрт шалгарсан бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээнд эмийг хугацаа дуусахаас 3 сарын өмнө буцааж солиулж авах талаар заасан байгаа. Төсвийн үр ашгийн хүрээнд энэ үйлдлээ хянадаг бол эм актлах асуудал байхгүй болно/		Ж.Бүжинханд	Акталж устгасан шийдвэр, комиссын акт, зураг бусад материалыг хянасан бөгөөд 2019, 2020 оны эмний үлдэгдлүүд байсан бөгөөд тухайн компанид буцаан өгөх гэсэн боловч он дамжсан гээд аваагүй байна
2022.02.11	2022.02.11		+			Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг дутуу төвлөрүүлсэн харагдаж байна. Хэмнэсэн зардал 1739710.8 төгрөг байхад төвлөрүүлсэн нь 197830.8 төгрөг буюу 1541880 төгрөгийг орон нутагт дутуу төвлөрүүлжээ		Ж.Бүжинханд	Орон нутгаас орж ирсэн санхүүжилт 1,545.0 мянган төгрөгөөр дутуу орж ирсэн бөгөөд үлдэгдэл 197,8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байгаа
2022.02.11	2022.02.12		+			Эмийн хугацаа дуусаад акталсан зөрчлийн хувьд тендэрт шалгарсан компанитай байгуулсан гэрээ, шууд гэрээ байгуулаад авсан эмийг ялгах харах. Гэрээ байгуулсан газраас нийлүүлсэн бол гэрээний үзүүлэлтэд 1 жилийн дотор хугацаа дуусах эмийг нийлүүлэхгүй гэж тусгасан эсэхийг үзэх. Хэрвээ тендэрт шалгарсан компанитай авсан эмийн хугацаа дууссан, шууд гэрээ байгуулсан газраас аваад хугацаа дууссан байдал зөрчилд аваад албан шаардлага өгөх нь зүйтэй байгаа цаашид анхаараарай		Д.Эрдэнэчимэг	өмнөх онуудын үлдэгдлүүд актлагдсан байна. Тухайн жилдээ хугацаа нь дууссан эмийг буцаалгаж солиулсан байна. Энэ өмнөх онуудаас хэрэглэгдээгүй үлдсэн эмийг акталж устгасан байна. Холбогдох нотлох баримтыг гаргуулан авлаа.
2022.02.11	2022.02.12		+			Тогтмол зардлыг дутуу санхүүжүүлсэнийг санхүүгийн албанаас тодрууллаа газрын төлбөрийн орлого тасраад ЭМТ, Сургууль, Цэцэрлэгийн санхүүжилтийг дутуу өгсөн байна. Энэ асуудлыг ТТЗ-ийн аудитаар авч үзээд шийдвэр өгөх саналтай байна.		Д.Эрдэнэчимэг	Орон нутгаас орж ирсэн санхүүжилт 1,545.0 мянган төгрөгөөр дутуу орж ирсэн бөгөөд үлдэгдэл 197,8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байгаа
2022.02.11	2022.02.12		+			Аудитын хураангуй тайланд залруулга, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг оруулаарай. Зөвлөмжийн загрын дагуу бичээрэй, /аудитын тайлан, хураангуй тайланд/ Акт, албан шаардлагын хяналтын хуудсыг хийгээрэй		Д.Эрдэнэчимэг	Тайланд оруулсан, бүртгэл хяналтын хуудсыг хөтөллөө.
2022.02.14	2022.02.14		+			Асуудлын бүртгэлд и-баримт илүү шивүүлсэн гэсэн боловч тайланд дутуу шивүүлсэн гэсэн байна харах		Х.Түвшинбаяр	Тайланд заслаа
2022.02.14	2022.02.14		+			Дараагийн аудитаар үзэх асуудал гэдэгт ТТЗ-ийн аудитаар үзэх үү дараа жилийн аудитаар үзэх үү		Х.Түвшинбаяр	Дараа жилийн аудитаар үзэхээр оруулсан
2022.02.14	2022.02.14		+			Шийдвэрийг Сайханжаргалгаар хянуулах		Х.Түвшинбаяр	Хянуулахаар 2022 оны 02.14-нд хүргүүлсэн

Аудитын тайланг баталгаажуулахыг зөвшөөрсөн

Дарга, Төргүүлэх аудитор

/Х.Түвшинбаяр/

оны сарын

8217144139  
ЦНОА00609018301

